



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/608

Булган сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын барилга байгууламжийн техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)
Гишүүд:	М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	С.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Иргэний төлөөлөл:	О.Буянбат (Булган сумын иргэн)
Нарийн бичгийн дарга:	А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010831